



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 4/315

Улаанбаатар хот

Тушаалын хавсралтад нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрүүл мэндийн яамны дэргэдэх зарим орон тооны бус зөвлөл, комисс, хорооны бүрэлдэхүүнийг батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2016 оны 195 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Дархлаажуулалтын зөвлөх хорооны бүрэлдэхүүн”-д оруулах өөрчлөлтийг нэгдүгээр, “Сэргийлэх тарилга (дархлаажуулалт)-ын дараах урвал, хүндрэлийн шалтгаан-хамаарлыг тогтоох хорооны бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай

2. Хороодыг мэргэжлийн арга зүйгээр хангаж, үйл ажиллагааг тогтмолжуулан, чадавхжуулахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Д.Нямхүү/-д даалгасугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2016 оны 195 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар баталсан “Дархлаажуулалтын зөвлөх хорооны бүрэлдэхүүн”, “Хороо байгуулах тухай” Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 504 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

031002

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 08 дугаар сарын 13 өдрийн  
43/5 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ЗӨВЛӨХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: П.Нямдаваа, Шинжлэх ухааны академи, Монголын анагаах ухааны академийн гишүүн, академич, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан
- Нарийн бичгийн дарга: Ч.Уранжаргал, Халдварт өвчин судлалын үндэсний төв(ХӨСҮТ)-ийн Дархлаажуулалтын албаны тархвар судлаач
- Нэг. Гишүүд:
- М.Алтанхуяг, Нийслэлийн Баянзүрх дүүргийн “Эрүүл өрх” өрхийн эрүүл мэндийн төвийн ахлагч (зөвшилцсөнөөр)
- М.Алтанхүү, Вирус судлалч, тархвар судлаач, АУ-ны доктор (зөвшилцсөнөөр)
- Ж.Амарсанаа, Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор, Гавьяат хуульч (зөвшилцсөнөөр)
- Д.Гантулга, Тархвар судлаач, АУ-ны доктор (зөвшилцсөнөөр)
- Ц.Ганхүү, Сумдын эмч нарын холбоо ТББ-ын гүйцэтгэх захирал (зөвшилцсөнөөр)
- Д.Даваалхам, АШУҮИС-ийн Эпидемиологи, биостатистикийн тэнхимийн эрхлэгч, АУ-ны доктор, дэд профессор (зөвшилцсөнөөр)
- Д.Мөнхөө, Хүүхдийн эмч, Гал голомт ТББ-ын тэргүүн, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан (зөвшилцсөнөөр)
- Ж.Мэндсайхан, Вирус судлалч, АУ-ны доктор (зөвшилцсөнөөр)
- Д.Нарангэрэл, ЭМЯ-ны Тандалт шуурхай удирдлагын хэлтсийн дарга
- С.Наряд, Тархвар судлаач, Эрүүл мэнд, дархлаажуулалт ТББ-ын тэргүүн (зөвшилцсөнөөр)

М.Туяа, Хүүхдийн эмч, “Пневмококкийн вакцины үр дүнгийн үнэлгээ” судалгааны үндсэн судлаач (зөвшилцсөнөөр)

А.Сарантуяа, Монголын үндэсний телевизийн сэтгүүлч (зөвшилцсөнөөр)

Хоёр. Мэргэжлийн зөвлөхүүд: ЭМЯ-ны Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн

ЭМЯ-ны Лабораторийн ерөнхий мэргэжилтэн

ЭМЯ-ны Эм зүй, эм судлалын ерөнхий мэргэжилтэн

ЭМЯ-ны Сувилахуйн ерөнхий мэргэжилтэн

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Халдварт өвчний тандалт, сэргийлэлт эрхэлсэн дэд захирал

Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн захирал

Эх хүүхийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хүүхдийн клиникийн захирал

Сангийн яамны Эрүүл мэндийн сайдын багцын төсвийн төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн төлөөлөгч (зөвшилцсөнөөр)

ДЭМБ-ын суурин төлөөлөгчийн газрын Дархлаажуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

НҮБ-ын Хүүхдийн сангийн суурин төлөөлөгчийн газрын Эрүүл мэндийн асуудал хариуцсан мэргэжилтэн (зөвшилцсөнөөр)

-оОо-



Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 2 дугаар сарын 14 өдрийн  
64/315 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

СЭРГИЙЛЭХ ТАРИЛГЫН (ДАРХЛААЖУУЛАЛТ)-ЫН ДАРААХ УРВАЛ  
ХҮНДРЭЛИЙН ШАЛТГААН-ХАМААРЛЫГ ТОГТООХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Б.Баясгалантай, ЭМЯ-ны Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн
- Нарийн бичгийн дарга: О.Дашпагам, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Дархлаажуулалтын албаны дарга
- Гишүүд: Д.Нарангэрэл, ЭМЯ-ны Тандалт, шуурхай удирдлагын хэлтсийн дарга
- Э.Баярмаа, ЭМЯ-ны Эмгэг судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, АШУҮИС-ийн Эмгэг бүтэц үйл судлалын тэнхимийн эрхлэгч
- Ч.Эрдэнэцэцэг, ЭМЯ-ны Ерөнхий мэс засал судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, АШУҮИС-ийн Мэс заслын тэнхимийн багш
- Т.Хосбаяр, ЭМЯ-ны Лабораторийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн, АШУҮИС-ийн Молекул биологи, удамзүйн тэнхимийн багш
- П.Батхуяг, ЭМЯ-ны Хүний эмийн зөвлөлийн Эм судлалын салбар зөвлөлийн дарга
- Б.Болормаа, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Мэдрэлийн тасгийн их эмч
- Ц.Чинбаяр, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Эрчимт, эмчилгээний тасгийн эрхлэгч
- Г.Сүрэнханд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн зөвлөх, тархвар судлаач
- Ж.Соёл-Эрдэнэ, Хүүхдийн харшлын эмч, Төмөр замын нэгдсэн эмнэлгийн чанарын албаны дарга (зөвшилцсөнөөр)
- Ч.Отгонцэцэг, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эм, биобэлдмэлийн хяналтын улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)

Б.Оюунцэцэг, Эмчилгээний чанарын хяналтын  
улсын ахлах байцаагч (зөвшилцсөнөөр)

Ш.Үүртуяа, АШУҮИС-ийн Эмгэг бүтэц үйл  
судлалын тэнхимийн эмгэг физиологийн багш  
(зөвшилцсөнөөр)

М.Цэрэнбат, АШУҮИС-ийн Эмгэг бүтэц үйл  
судлалын тэнхимийн багш (зөвшилцсөнөөр)

Л.Энхсайхан, АШУҮИС-ийн Микробиологи,  
иммунологийн тэнхимийн багш (зөвшилцсөнөөр)

-oOo-